

Соноор сэрэмжтэй байх


2018 оны 4-р сар

Соноор сэрэмжтэй байх нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлэхэд зайлшгүй чухал шинж чанаруудын нэг юм. “Соноор сэрэмжтэй байх” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь үйлдвэрт ажилладаг хүн бүр дараахийг хэрэгжүүлдэг гэсэн үг.

- Үйлдвэрлэлийн процесс болон материалтай холбоотой аюулуудын талаарх анхаарал болгоомж өндөр түвшинд байдаг.
- Илүү ноцтой нөхцөлд хүргэж болзошгүй тохиолдлыг урьдчилан сануулж байж болох шинж тэмдгүүдийг тогтмол анзаарч сэрэмжилдэг. Үүнд осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх зэрэг үйлдэл багтана. (2018 оны 3-р сарын *Beacon*).
- Өнгөрсөн хугацаанд ажлын гүйцэтгэл болон аюулгүй ажиллагааны үзүүлэлт сайн байсан учраас илэрч болзошгүй өөртөө хэт итгэх, бардах байдлаас зайлсхийдэг.

1912 оны 4-р сарын 15-ны өдөр (106 жилийн өмнөх энэ сард) Титаник хөлөг онгоц хойд Атлантын далайд мөсөн уул мөргөснөөсөө хойш 3 цагийн дараа живсэн бөгөөд 1500 гаруй хүн амь үрэгдсэн. Тус ослын хувьд Титаникийн бүтэц болон үйл ажиллагаатай холбоотой соноор сэрэмж алдсан жишээ олон байдаг. Тухайлбал:

- Хөлөг онгоцыг “живэх боломжгүй” гэдэгт итгэлтэй байсан учраас аюулгүй ажиллагааны маш чухал асуудлууд дээр буруу шийдвэрүүд гаргасан. Жишээ нь: Ус нэвтрүүлдэггүй тусгаарлагч хананууд төв тавцангаас доош хоёр тавцан үргэлжилсэн байсан. Аврах завь “шаардлагагүй” гэж тооцоод 64ш байсныг 16ш болгож хассан тул бүх зорчигч болон хөлгийн багийнханд хүрэлцээгүй.
- Хөлгийн дарга хөлгийг удирдах өөрийн ур чадвар ба хөлгийн хүч чадалд хэт итгэлтэй байсан гэж үздэг.
- Хөлөг мөс хөвж буй замаар өндөр хурдтай явсан. Бусад хөлгүүдээс мөсөн уулны талаарх анхааруулгууд ирж байсан боловч хурд сааруулах ямар ч тушаал өгөгдөөгүй.



Та мэдэх үү?

Соноор сэрэмж алдагдах нь үйлдвэрлэлийн эмгэнэлт осол тохиолдох нэг хүчин зүйл байсаар ирсэн. Жишээ нь: 1984 оны 12-р сард Энэтхэг улсын Бопалд хорт хий (метилен диизоцианат – MIC) алдагдсаны улмаас хэдэн мянган хүн амь насаа алдсан. Тус эмгэнэлт үйл явдлын дараа аюулгүй ажиллагааны маш чухал хэд хэдэн системийн ажиллагаа нэлээд хугацааны туршид доголдолтой байсныг олж илрүүлсэн. Үүнд:

- Хий хуваарилагч болон гаргах хоолой эвдрэлтэй байсан.
- Хий хадгалах танкны хөргөх системийг ашиглаагүй орхисон байсан.
- Ослыг үүсгэсэн шалтгаан болох усны бохирдлоос хамгаалахын тулд турбаны хаалтууд угсраагүй байсан. Хэрэв угсарсан байсан бол ослоос сэргийлэх боломжтой байсан.

Та юу хийж чадах вэ?

- Үйлдвэрлэлийн процесс болон материалтай холбоотой аюулуудын талаар мэдээлэлтэй байх хэрэгтэй. Тохиолдож болох хамгийн ноцтой осол юу байж болох, түүнээс сэргийлэх ямар аюулгүйн систем, процедурууд бэлэн байгаа тухай мэддэг бай. Тэдгээр систем, процедурууд нь бүрэн зөв хэрэгжиж байгаа эсэхийг хэрхэн баталгаажуулах талаар мэдлэгтэй бай. Ямар нэгэн доголдол ажигласан бол удирдлагын багт мэдээл.
- “Тийм зүйл энд тохиолдохгүй” эсвэл “тийм зүйл надад тохиолдохгүй” гэж хэзээ ч бүү бод. Тохиолдох боломжтой!
- Тохиолдож болзошгүй хамгийн ноцтой ослоос болгоомжилж байхыг үйлдвэрийн бүх ажилтанд зөвлөх хэрэгтэй ба тэр нь яг одоо ч тохиолдох боломжтой. Түүнээс сэргийлэхийн тулд та юу хийж чадах, тохиолдсон нөхцөлд юу хийх ёстой талаар мэдлэгтэй байж, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах тухай журмыг мөрдөхөд ямагт бэлтгэлтэй бай.
- “Хамгийн ноцтой осол”-оос гадна танай үйлдвэрт гарах боломжтой бүхий л хүрээний тохиолдлуудын учруулж болзошгүй нөлөөллийн талаар мэдээлэлтэй бай.

**“Амьд луутай ойрхон амьдарч байгаа бол түүнийг хайхрахгүй орших нь бүтэлгүйтэлд хүргэж болно.”
– J. R. R. Tolkien, “Хоббит,” XII бүлэг**